



БАВУУЖАВЫН НҮГНЭЙЖАВ (1899-1932): НАМТАР, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ, ЭРДЭМ СУДЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС

Цэвээндашийн Дэлгэрсайхан^а

^аМУБИС-Багшийн сургууль, дэд проф., доктор (Ph.D)

Холбоо барих зохиогч: delgersaikhan@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2023.11.12

Хянагдсан: 2023.12.12

Зөвшөөрсөн: 2023.12.25

Хураангуй

Монголд 1920-оод оны дундуур ирж, тэр үеийн дунд сургууль болон Оюутны сургуульд багш, Монгол улсын Дотоодыг хамгаалах газрын нууц ажилтан, 1926-1928 онд Москва дахь Монголын Элчин Сайдын Яамны Нарийн бичгийн дарга зэрэг хариуцлагатай ажил алба хашиж байсан, Япон улсад дээд сургууль төгссөн, Япон, Хятад, Орос хэлтэй эрдэмтэн багш Б.Нүгнэйжавын талаар урьд өмнө төдийлөн ил болоогүй архивын ховор баримт материалыг цуглуулан, түүнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад энэхүү өгүүллийн зорилго оршино.

Түлхүүр үг

Бага сургууль, дунд сургууль, багш нарыг бэлтгэх сургууль

Удиртгал

Түүхэн баримт сурвалж бичиг, ном зохиолд Нүгнээжав, Нүгнэйжав, Нүннээжав, Нүгнийжав, Нүннайжав, 1931 онд дунд сургуулийн багш, ажилчдыг оросоор бичсэн бүртгэлийн 15-рт “Нукнайжап – час. преподаватель” (МУУТА, ТБА, Х.6, Д.2, ХН.23, х.77) гэх зэргээр олон янзаар бичигдсэн хүмүүн бол харчин Бавуужавын хүү Нүгнэйжав билээ.

Бид энэхүү номд түүний нэрийг уйгаржин бичгээр Нүгнижиба хэмээн бичсэн болон 2012 оны 11 сарын 23-ны өдрийн 714 дугаар МУ-ын Дээд шүүхийн Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолд бичснийг тус тус үндэслэн, түүний нэрийг “Нүгнэйжав” хэмээн бичиж байна.

Түүний тухай баримтууд нь харьцангуй бага, судалгааны эргэлтэд төдийлөн ороогүй тул Монгол Улсын Үндэсний Төв Архивын сан хөмрөг болон Монгол Улсын Үндэсний номын сангийн “Гар бичмэл, Монгол судлал” -ын сан хөмрөгт шүүлт хийж, түүний намтар түүх, үйл ажиллагаа, байцаалтын тэмдэглэл, сургалтын ном, сурах бичиг орчуулсан зэрэг баримт материалыг гол болгон өгүүлэхийг зорив.

Үндсэн хэсэг 1. Б.Нүгнэйжавын товч намтар

1926-1927 онд Монголд ирсэн Хятадын түүхч Ма Хэтяний “Ар, Өвөр Монголоор зорчсон тэмдэглэл” бүтээлд “Үндэсний их сургуулийн сургалт хариуцсан захирал Хань Шаокан нь Жэхэгийн монгол үндэстэн, японд суралцсан, дунд сургуульд багшилж байсан” (Ма Хэтянь, 2021, х. 149) хүн бол Бавуужавын Нүгнэйжав хэмээн орчуулагч Б.Гэрлээ түүний нэрийг хятад ханзаар бичиж, тайлбар зүүлт хийжээ. Үүнээс үзвэл Нүгнэйжав нь Хань Шаокан хэмээх хятад нэртэй байжээ.

З.Цэрэндулам “Зогсоолонгийн Доржсүрэн” бүтээлдээ Б.Нүгнэйжавын талаар товч мэдээлэл бичжээ. “Японд сургууль төгссөн. Хоёр дүү нь мөн японд сурч байсан, өндөр боловсролтой олон хэл мэддэг. Ямар ч хичээлийг заахад бэлэн байдаг. Өөрөө аман хуур сайхан тоглодог, хүүхдүүд лапто, гродки (модон бөмбөг)-өөр тоглодог, хаалга гаргах (ердийн бөмбөгөөр тоглох) гэх мэт олон тоглоом зааж байж билээ. Монгол улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн Ц.Зандраагийн эгч Цэрэндэжид гэгч орос хэлэнд маш сайн, сайхан хүүхэнтэй гэр бүл болж байсан. Авгайгаараа орос хэл заалгаж байсан гэдэг.

Сурагчдадаа гоо сайхны хүмүүжил олгох, хүүхдийн сэтгэлзүйг нээж баярлуулж чаддаг, гоё хувцасладаг, дуу хөгжимд дуртай болгосон, хүүхдэд янз бүрийн тоглоом заадаг учир сурагчдынхаа хайрыг татсан хүн байсан гэж ахмад сурагч Т.Рагчаа, С.Дашимаа нар дурсан ярилаа” (Цэрэндулам, 2003, х.56) хэмээжээ.

1930 оны 3 дугаар сарын 26-нд Багшийн сургуулийг төгсөж, багш болсон Д.Цэвэгмид “Эргэн санахад” номдоо “...нэгэн өдөр III ангиас Раднаа, Баасан, II ангиас намайг захирал багш Б.Нүннайжав дуудан, “Шинэ сургуулиудад багш нар шаардагдаж, та нарыг урьдчилан төгсгөх болов. Одоо Гэгээрүүлэх явдлын яаманд очих хэрэгтэй” (Цэвэгмид, 2005, х. 54-55) хэмээсний дагуу Ардыг Гэгээрүүлэх Явдлын Яаманд түүнийг очиход, Хар бологсдын бэлтгэл сургуульд багшаар томилсноор багшлах ажлын гараагаа эхэлсэн тухай дурсан бичжээ.

1930 оны 9 сараас 1933 оны 8 сар хүртэл Багшийн сургуулийн захирлаар ажилласан Кино хорооны анхны дарга асан Доржийн Гончиг гуай “..Ленинград хотод Дорно дахины хэл судлалын институтэд 1924 оны намар суралцахаар явж очоод, бэлтгэл сургуульд 2 жил, улмаар үндсэн ангид нь 3 жил суралцаж байтал, Гэгээрлийн яамнаас дуудаж ирүүлээд, Багш нарыг бэлтгэх сургуулийн захирлаар /1930 оны 9 сараас/ томилов. Тэр ажлыг Нүгнэежаваас авсан” хэмээжээ.

Үүнээс үзвэл Гажидын Бадрахын дараа Бавуужавын Нүгнэйжав нь Багшийн сургуулийн захирлаар ажиллаж байгаад, 1930 онд хилс хэрэгт баривчлагдан явсан байна.

Тагнуулын Ерөнхий газрын Тусгай архивын баримтад “Өширхий /Өширин/ овогтой Нүгнийжав нь Өвөр /Дотоод/ Монголын Монголчин хошуу, ард хар, дотоод монгол, эрэгтэй, нас 32 /1931 оны байдлаар/, ам бүл 2, хөрөнгийн хувь: эсгий гэр 1, Дотоод Монгол ба МАХН-ын гишүүн, япон, хятад, монгол бичиг мэднэ. Орос, англи хэл бага зэрэг мэднэ. Харчин Бавуужавын хүүхэд, Ардын Гэгээрүүлэхийн сургуульд багш, Улаанбаатар хотын 19 дүгээр ангийн 1805 тоот хашаанд оршин суудаг. Ял шийтгэл хүлээж яваагүй...” (ТЕГ, 2012, х. 1) гэсэн мэдээлэл байна. Мөн судлаач Н.Батболдын өгүүлэлд “Энэхүү Нүгнэйжав бол Монголын түүхэнд нэр цуутай Бавуужав гүнгийн гурван хүүгийн ууган нь юм. Удаах дүү нар нь Жонжууржав,

Ганжууржав хоёр ажээ. Өшрөг нэрээр эцэглэсэн нь эцгийнхээ өшөөг Хятадаас авна гэсэн утгатай гэнэ” (Батболд, 2017, х.17) гэжээ.

20 оны /1930/ 5 сарын 3-наас 1932 оны 2 дугаар сарын 17-ны өдөр хүртэл 17 удаа өгсөн мэдүүлгээс нь үзвэл тэрээр “...Япон улсын дээд сургуульд 11 жил болсон бөгөөд тэр үед монгол хэл бичиг зааж байсан Гомбобадамжав монголд ирэх тухайд Буминтайн дүү Хуаминтай, Эрхэмбат нар Монголын сургуульд орохыг хүсэж байсан учраас мөнхүү Гомбобадамжав энд ирсний дараа надад ирүүлсэн захидалдаа би үүгээр Ерөнхий сайд Цэрэндорж нартай ярилцаж, даруй ирүүлэхээр болсон тул одоо наашаа ирсүгэй хэмээснээр Хуаминтайн хамт 15 онд /1925 онд/ Бээжин хотноо хүрэлцэн ирвэл Дотоод монголын Намын Төв хорооны дарга Цэрэндонровтой уулзаж, миний бие намын гишүүнд элссэн. Дараа нь Рааш бид нарыг Дотоод Монголд ажил хийлгэх учир Гадаад Монголын намын байдалтай танилцуулан ирүүлэхээр Цэрэндонровын хамт тус хотноо ирж, оюутан, сургуулийн зэрэг газруудад захирал, багшийн албыг хаасаар эдүгээ хүрчээ. Намайг намын 2 дугаар шалгалтын үеэр Японы тагнуул байж магадгүй хэмээсэн мэдээ, шүүмжлэл гарсан гэж уул мэдээг дарга Гэндэн, Дугаржав нараас уншиж өгсөн юм. Би тийнхүү тагнуул болох ч байтугай 15 онд /1925/ Япон улсаас ирсэн 13 хүмүүсийн хэргийг байцаахаар ДХГ-аас томилогдсон цоохор Намсрайн хамт Егүзэрт очиж, дээрх хүмүүст элдэв арга хэрэглэн байцааснаар тэдний дунд нуугдмал тагнуул болж ирсэн японы 2 цэргийн даргыг илрүүлж, нөгөө эрдэмтэн 11 хүмүүсийн хамтаар нааш Улаанбаатар хотноо хүргүүлэн ирж байсан зүйл бий ” хэмээжээ.

Дээрх мэдээллээс үзвэл, Нүгнэйжав нь 1924 онд Монголд ирсэн Гомбо Бадмажаповтой японд сурч байхдаа танилцжээ. Оросын интернэтэд бичсэнээр “Гомбо Бадамжапов нь эмч Цыбыктаровтой хамт эх нутгаа орхин гарахад хүрч, Өргөөд түр зуур шилжин суурьшиж байжээ. Цыбыктаров Консулын газарт эмчээр, харин Бадмажапов Цахилгаан мэдээний ерөнхий газар ажиллаж байтал Барон Унгерний цэргүүд монголд ирж, харгислал үйлдэн, улмаар Цыбыктаров түүнд өртөж хөнөөгджээ. Гомбо Бадмажапов гэр бүлийн хамт оргон зайлж, Бээжинд их сургуульд багшаар ажиллажээ. Японд Токиогийн Их сургуульд 2 жил монгол хэлээр лекц уншжээ. 1924 онд Монголын Засгийн газрын урилгаар Хууль зүйн яаманд зөвлөхийн албан тушаалд томилогдон иржээ” (<https://www.infpol.ru/100375-sudba-selenginskogo-bulagata-gombo-badmazhapova-istoricheskaya-khronika/>) хэмээжээ.

Ийнхүү Б.Нүгнэйжав нь Гомбо Бадмажаповын дэмжлэгтэйгээр 1925 онд Монголд ирсэн нь тодорхой байна.

Ма Хэтяний номд дурдснаар Б.Нүгнэйжав нь 1926 оны байдлаар Оюутны сургуульд сургалт эрхэлсэн дэд захирлын орон тоонд ажиллаж байсан байна. Гэвч түүнтэй хамт ирсэн Рааш гэгч нь хувийн өш хонзонгоор “Японы тагнуул байж магадгүй” хэмээн мэдүүлснээр намын II шалгалтаар түүнийг ямар ч үндэслэлгүйгээр “тагнуулч” хэмээн баривчилж, байцаалт явуулжээ.

Үндсэн хэсэг 2. Б.Нүгнэйжавын сурган хүмүүжүүлэх, эрдэм судлалын үйл ажиллагаанаас

МАХН-ны II шалган цэвэрлэлтийн 1929 оны баримт материалд Б.Нүгнэйжавын анкет хуудас байна. “МАХН-ын шалгалтад орох гишүүдийн байдлыг тодорхойлсон анкет хуудас” ны асуулгад тэрээр дараах байдлаар хариулжээ. “Овог: Өшөрэн, Нэр: Нүгнэйжав, ард, хар, эрэгтэй. Улаанбаатар хотын жинхэнэ харьяат бөгөөд дөрөвдүгээр хорооны тавдугаар аравны Багш нарыг бэлтгэх сургуулийн танхимд. Монгол, хятад, япон бичиг мэдмүй. Япон улсын сургуульд 15 наснаас эхлэн эм хэрэгсэлээр 11 жил явсан. Элдэв ухааны сургууль ба цэргийн сургууль мэдмүй. Дуу хөгжим мэдэх үгүй. Одоо сургуулийн багш болох тул аливаа заах арга хийгээд хэрхэн сургуулийн явдлыг сайжруулах тухай оролдож буй. Гэрийн дотор эхнэр ба нялх хүүхдийн хамт гурвуулаа буй. Мал үгүй боловч 2300 төгрөгийн үнэ бүхий хашаа байшин баймуй. Үүнийг бод болгон бодвоос 26 болмой. Өөр зүйлийн орлого огт үгүй бөгөөд гагцхүү албанаар гол болгон аж төрмүй. 15 (1925) дугаар онд сургууль төгсгөж ирснээс хойш Ардыг Гэгээрүүлэх Яамнаа байцаагч, зохиох, бүртгэх зэрэг түшмэлийн албыг хааж, тэндээс Оюутны сургуулийн эрдэмтэн багш болон эдүгээд болвоос мөнхүү сургуулийн захирал ба эрдэмтэн багш жич дунд сургуулийн багш зэргийн албанаа буй. Цэргийн газрын албан хаасан үгүй. Монголын ард нийтийг эрдэм соёлд дэвшүүлэн гэгээрүүлэн боловсруулж, улмаар хувьсгалын үзэл суртлыг дэлгэрүүлэн гишүүн болсны нэг хувийг бүтээхийг хичээн зүтгэж буй. 17 (1927) дугаар онд Ардыг Гэгээрүүлэх Яамнаа шинэ үүр байгуулахын хамт дотоод монголын намаас шилжиж гишүүн болсон. Намд өөрийн дураар элсэж орсон бөгөөд энэхүү нам болвоос үнэхээрийн бүх дэлхийн үгээгүй ядуу иргэдийг туслан тэтгэх жинхэнэ хувьсгалч нам мөн ба нэн ялангуяа намын долоодугаар их хурлаас хойш улмаар таньж, түүний үнэн чанарыг мэдэн биширч байнам. Гишүүний хувиар чадах чинээгээр зүтгэж байсан боловч гавьяа дурсгал байгуулсан зүйл үгүй. Тус намын дүрэм ба суртлыг дунд зэрэг мэдэх боловч чухам зүйл дараалан мэдэх үгүй. Бас шийтгүүлсэн зүйл үгүй. Улмаар хувьсгалын явдлыг чанартай болгон үзэл суртлыг олон нийтэд дэлгэрүүлж, гадаад, дотоод эзэрхэг харгисуудыг даран сөнөөхийг хичээх учир юуны урьд үндсэн суурь болох эрдэм боловсролын явдлыг чухалчлан үзэж, хичээн оролдож баймой. Япон улсын шатар наадмын зүйлийг бага мэдэх боловч наадсан удаа үгүй ба архи дарс огт уух үгүй. Лам нартай барилдлага үгүй, ноёд түшмэдийг эзэрхэг харгис дайсан хэмээн санамой. 16 (1926) дугаар онд үйлдвэрчний гишүүн, 19 (1929) дүгээр онд хоршооны гишүүн..” (МУУТА, УТНОНББА, ЦХ.3, Д.1, ХН.68, х.28-29) хэмээн хариулжээ. Харин намын “Нэгдүгээр шалгалтаар шалгагдсан эсэх, үгүй аваас юуны учир шалгагдсан үгүй хэрхсэн” гэсэн асуултад “Хятадын Шанхай хотноо хэвлэлийн машиныг худалдан авахаар Ардыг Гэгээрүүлэх яамнаас томилогдон албанд явж эзгүй байсан учир шалгагдсан үгүй” хэмээн тайлбарлажээ.

Тэрээр баривчлагдаад, нэг удаагийн мэдүүлэгтээ: “...намайг тийнхүү японы тагнуул гэх зэрэг мэдээ, шүүмжлэл оруулсан этгээд бол надтай хамт ирсэн Рааш элдэв үл бүтэх явдалтай учраас албан тушаалаасаа зайлуулагдан, надтай атаархан тэмцэхдээ тийнхүү худал мэдээ зүйлийг оруулсан хэмээн Гажид Бадрах нараас хэлж байсан зүйл бий. Миний бие тус хотод хувийн доктор /эмч/ байсан японтой энгийн

танилцаж, түүнд ирсэн япон сонинг үзэж байсан бөгөөд тэрхүү сонинд Монгол улаан Оросын гарт оржээ хэмээх буюу Оросоос Үүд хотод хэдэн мянган цэрэг ирүүлэв гэх зэрэг утга үгтэй сонин байсныг уншиж байсан нь үнэн. Гянданд сууж байхдаа заримдаа ингэж байхаар үхчих юмсан хэмээн боддог байсан. Заримдаа бачимдахдаа хүн алчихаад хэрэгт орсон хэмээн гянданд сууж байсан нь дээр юм” (ТЕГ-ын Тусгай архив, 2012, х.2) хэмээн мэдүүлжээ.

Монгол Улсын Үндэсний номын санд Б.Нүгнэйжавын Япон хэлнээс орчуулсан “Бага сургуулийн тоо бодлогын бичиг” нэгдүгээр, хоёрдугаар, гуравдугаар дэвтэр хадгалагдаж байна. Эдгээр дэвтрийн нүүр хавтасны дотор тал баруун доод буланд “Нүгнэйжав японоос орчуулсан эх ноорог” хэмээн гараар бичсэн байна. Эдгээр дэвтэрт тоог нэмэх, хасах, үржүүлэх, хуваах үйлдлүүд бүхий олон дасгал даалгаврыг тусгаснаас гадна өгүүлбэртэй бодлогуудыг мөн оруулж, зарим даалгаврыг нь зургаар илэрхийлсэн зэрэг тун сонирхолтой юм.

Мөн “Биеийн тамирыг сайжруулах бичиг” хэмээх номын төгсгөл хуудсанд “Энэхүү биеийн тамирыг сайжруулах бичгийг ард Нүгнэйжаваар Япон улсын хэлэн дээрээс орчуулав” гэсэн байна.

Судалгааны үр дүн

Багш нарыг бэлтгэх сургуулийн багш, захирлаар ажиллаж байсан тухайн үед дээд боловсролтой цөөн хүний нэг байсан харчин гүн Бавуужавын Нүгнэйжавын тухай баримт мэдээлэл маш бүрхэг байсныг хувь хүний архив болон МУҮТА-ын сан хөмрөгөөс шүүн илрүүлж, Багшийн сургуулийн 100 жилийн ойд зориулсан бүтээлийн 207-209-р талд “Багш нарыг бэлтгэх сургуулийн захирал Бавуужавын Нүгнэйжав (1899-1932)” гарчигтайгаар нийтэлж хэвлүүлсэн билээ.

Харин энэхүү өгүүлэлд уг номд орсон зарим баримтыг ашиглахын зэрэгцээ Б.Нүгнэйжавын талаар өгүүлэл бичиж хэвлүүлсэн судлаач Н.Батболдын судалгаатай харьцуулахын зэрэгцээ МУҮНС-д хадгалагдаж байгаа, одоогоор бидний мэдэж буй түүний Япон хэлнээс орчуулан хэвлүүлсэн 1 ном, орчуулсан 3 дэвтэр эх ноорогийн тухай товчлон өгүүлэв.

Дүгнэлт

Үүнээс үзэхэд тэрээр япон, хятад хэлний мэдлэг боловсролтойн дээр Улаанбаатар хот дахь зарим япончуудтай танил, харилцаа холбоотой байсан зэрэг нь “Японы тагнуул” байх гэсэн хардлага сэрдэлтэд өртөх гол үндэслэл болсон бололтой.

Ийнхүү Б.Нүгнэйжав (1899-1932)-ыг улс төрийн тагнуул хийснийг шалгаж тогтоосон тодорхой баримт нотолгоо байхгүй ял шийтгэл оногдуулан, Дотоодыг хамгаалах газрын дэргэдэх Тусгай комиссын 1932 оны 3 дугаар сарын 24, 25-ны өдрийн 5 дугаар хурлын тогтоолоор хуулийн зүйл анги заалгүйгээр “Японы тагнуул” хэмээн буудан алах ялаар шийтгэжээ.

2012 оны 11 сарын 23-ны өдрийн 714 дугаар МУ-ын Дээд шүүхийн Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолд дээр дурдсан Тусгай комиссын 1932 оны тогтоолыг хүчингүй болгож, түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгасан байна.

Өрнө, дорнын боловсролтой, эрдэмтэн багш Б.Нүгнэйжав нь хийж бүтээх залуу насандаа хилс хэрэгт хэлмэгдэн шийтгэгдсэн ч Монгол Улсад орчин цагийн боловсролыг үүсгэн хөгжүүлэх, ялангуяа багшлах боловсон хүчнийг бэлтгэхэд онцгой хувь нэмэр оруулсан хүмүүсийг нэг байсан нь архивын баримтуудаар нотлогдож байна.

Ном зүй

Батболд, Н. (2017). Б.Нүгнэйжавын зурагт нугалбар. Тусгаар тогтнол сэтгүүл. №4/40/. 17-18-р талд.

Дэлгэрсайхан, Ц. (2022). Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Багшийн сургууль-100 жил. Тэргүүн боть (1912-1942 он). Түүхэн эх сурвалж, баримт, түүхэн зураг. Улаанбаатар: Адмон принт.

Жамбалдорж, Б. (1989). Доржийн Гончиг гуайтай уулзаж ярилцан, “Сэтгэл гандаагүй буурал” тэмдэглэлийг 1989-11-29-нд бичжээ (бичгийн машинаар цохьсон 8 нүүр хуудас).

Ма Хэтянь. (2021). Ар, Өвөр Монголоор зорчсон тэмдэглэл. (Орч. Гэрлээ, Б). Улаанбаатар: Эрдэм Гэгээрэл Паблишинг.

МУУТА, ТБА, Х.6, Д.2, ХН.23, х.77

МУУТА, УТНОНББА, ЦХ.3, Д.1, ХН.68, х.28-29

МУУНС, 2680/96, 511-т 50, 1937/ 511-т.50, 2681/96, 511 -т 50.

Цэвэгмид, Д. (2005). Эргэн санахад. (Дурсамж, тэмдэглэл). Эмхт Д.Нямаа. Улаанбаатар

Цэрэндулам, З. (2003). Зогсоолонгийн Доржсүрэн. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

**BAVUZHAY NUGNEIZHAY (1899-1932): BIOGRAPHY,
TEACHING AND RESEARCH ACTIVITIES**

Delgersaikhan.Ts
Assistant prof., Ph.D., Teachers School, MNUE

Corresponding author: delgersaikhan@msue.edu.mn 

Abstract

He came to Mongolia in the mid-1920s and served in responsible positions such as a teacher at a middle school and a Students (Teachers) school at that time, a secret agent of the Ministry of Internal Defense of Mongolia, a secretary of the Mongolian Embassy in Moscow from 1926 to 1928, and a university in Japan. The purpose of this article is to collect and analyze rare archival materials about B. Nugneizhay, a Japanese, Chinese, and Russian-speaking scientist and teacher who graduated from the university of Japan.

Keywords

Elementary school, middle school, teachers training school
